Монголын ОҮИТБС-ыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн Арван наймдугаар хуралдааны тэмдэглэл /2019-12-19/

Монголын ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 18- р хуралдаан 2019 оны 12-р сарын 19-ны өдрийн 10 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хурлын танхимд эхлэв.

Хуралдаанд Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтсийн дарга Д.Дамба, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Ч.Чимидсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ахлах мэргэжилтэн Шижир-Эрдэнэ, Үндэсний аудитын газрын хэлтсийн дарга Бундхорол, Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга С.Дуламсүрэн, Үндэсний статистикийн хорооны хэлтсийн дарга Эрдэнэ-Сан, Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Т.Гантөмөр, Нүүрс ассоциацийн ТУЗ-ын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Эрдэнэт үйлдвэр ХХК-ны эдийн засаг, маркетингийн хэлтсийн орлогч дарга Д.Галбаатар, Монполимет ХХК Группын гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Оюутолгой ХХК-ны ахлах менежер Т.Мөнхбат, Петрочайна дачин тамсаг ХХК-ны ерөнхий нягтлан бодогч н.Болормаа, ТАН эвслийн зохицуулагч Л.Төр-Од, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Захиргааны шинэ санаачилга ТББ-ын тэргүүн С.Цэрэнпүрэв, Ихбаян шарга ТББ-ын тэргүүн Л.Бор, ТАН эвслийн мэрэгжилтэн Т.Саруул, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд нар оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 33 гишүүдээс 24 гишүүд оролцож ирц 72,7 хувьтай байв.

Мөн хуралдаанд БДО ХХК-ийн удирдах партнер Г.Баянмөнх, аудит хариуцсан захирал Л.Баярцогзол, бусад аудиторууд, урилгаар Транспаренси Интернэйшнл Монгол байгууллагын ажилтан Мөнхжаргал, Татварын ерөнхий газрын ахлах байцаагч Ж.Батцэнгэл, Монголын байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Н.Наранцэцэг ажлын албаны Зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээллийн технологийн мэргэжилтэн О.Мөнхбат нар оролцов.

Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 18- р хуралдааныг, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Н.Нандинжаргал нээж үг хэлэв.

Н.Нандинжаргал: Юуны өмнө хоцорч ирсэндээ хүлцэл өчье, яаралтай асуудлаар Сайд дээр дуудагдаад ирлээ. Өнгөрсөн жилээс эхлэн ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийн дагуу ОҮИТБС-тай нилээд хамтарч ажилласан. Өнгөрсөн 6 дугаар сард Парист зохион байгуулсан хуралдаанд оролцож, бусад орнууд юу хийж байна, бид цаашдаа ямар түвшинд ажиллах ёстой, ямар гэрээг ил тод болгох хэрэгтэй зэргээр олон зүйлийг сонсож мэдсэн. Манай яамнаас зарим нэгэн бодлогын түвшинд ажиллаж байгаа. Өнөөдрийн хуралдааныг Дамба дарга удирдан явуулна, би Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хуралтай байгаа. 2020 он гараад яаманд 2-3 төсөл хэрэгжинэ. ОҮИТБС-ын чиглэлээр хамтран ажиллах саналыг зарим донор байгууллагуудад тавьсан байгаа, нэг нь албан ёсоор хариугаа өгсөн, ирэх 3 сараас ажиллах байх. Та нарын хөдөлмөр зүтгэлийг үрэн таран хийхгүй цаашдаа яамны бодлогод суугдаад салбарыг бодлого болгож ажиллана. Одоо санал, асуулт байвал хурлын өмнө асууж болно.

Л.Төр-Од: Саяхан ТАН эвслийн бүх гишүүдийн хурал болж, намайг ТАН эвслийн зохицуулагчаар сонгосон. ОҮИТБС-ын Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хуралдааныг идэвхжүүлэх, Парист болсон хурлаас гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил, шинэ стандартыг хэрэгжүүлэх, бүх түвшний гэрээг ил тод болгох зэрэг асуудлууд байгаа. Мөн ашиг хүртэгч эздийг ил болгох асуудал байна. Нээлттэй нийгэм форум, Байгалийн баялагийн засаглалын хүрээлэн Авилгатай тэмцэх газартай хамтран ОҮИТБС-ын талаар хэлэлцүүлэг хийж, үүнээс тодорхой дүгнэлт, зөвлөмж саналууд гарсан үүнийг хэлэлцэх ёстой гэж бодож

байна. Горимын асуудал гэвэл, манай ИНБ-ын зүгээс Үндэсний Зөвлөлийн хуралдааныг болж өгвөл улиралдаа нэг удаа, үгүй бол жилдээ 2-оос доошгүй удаа зохион байгуулах, Ажлын хэсгийн хуралдааныг хоёр сард нэг удаа хийх саналтай байна. Уг уулзалт хуралдаанаас гурван талаасаа тулгамдсан асуудлаа гаргаж, хэлэлцээд шийдвэрлэдэг баймаар байна. Манай хөгжлийн түншүүд уул уурхайн салбарын хандивлагчдын уулзалтыг албан болон албан бус журмаар хийж байгаа. Энэ уулзалтыг УУХУЯ илүү албажуулаад, АМГТГ, хувийн хэвшил, төрийн байгууллагын төлөөллийг оролцуулвал энэ салбарт өмнө нь хэрэгжиж байсан болон цаашдаа хэрэгжих төсөл хөтөлбөрийн уялдаа холбоо бий болж, нэмж санхүүжилт босгож хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх боломжтой харагдаж байна. Энэ талаар Олон улсын санхүүгийн байгууллагын төлөөлөл болон бусад донорууудтай ярьж байсан, ер нь дэмжих боломжтой юм байна.

Г.Нандинжаргал: Ер нь байнга ойрхон уулзаж байх хэрэгтэй. Ажлын хэсгийн уулзалтыг намайг байхгүй тохиолдолд ажлын хэсгийн дарга удирдаад явна. Гаднын төслийн хувьд донор байгууллагуудын уулзалт хэрэгтэй байгаа. Донор байгууллагууд ОҮИТБС-ыг дэмжиж ажиллах боломжтой гэдгийг харсан, ингэснээр авилга хээл хахуультай тэмцэх юм.

Т.Мөнхбат: Манай ОҮИТБС-ыг УУХҮ-ийн сайд удирдах болсноос хойш багагүй хугацаа өнгөрлөө гэсэн хэдий ч миний оролцсон хэд хэдэн уулзалтад салбарын сайд маань оролцохгүй байна. Парист болсон ОУ-ын уулзалтаас харахад энэ салбарт маш их анхаарал хандуулж байна. Манай улс Ерөнхий сайдын түвшинд байсныг УУХҮЯ-ны сайдын түвшинд авчирсан, сайд оролцохгүй байгаа ч Төрийн нарийн бичгийн дарга цаг гарган оролцож байгааг ойлгож байна. Энэ дээр бид хариуцлагатай хандмаар байна, хөтөлбөр ирэхэд дандаа сайдын нэр байдаг боловч бодит байдал дээр байдаггүй. Үүнийг анхаармаар байна, сайд өөрөө ирэх ёстой гэж бодож байна, гишүүд маань ч гэсэн цаг заваа гаргаж ирж байгаа, энэ талаар гишүүд маань ч саналаа хэлэх байхаа. Санаачилгын зүгээс сүүлийн жилүүдэд зарим мэдээллүүдийг цахим сайтаар мэдээлж байгаа боловч энэ нь хүмүүст хангалттай мэдээлэл болж чадахгүй байна гэдгийг гурван талын гишүүд хэлж байгаа. Өчигдөр "Байгаль эх хариуцлагатай уул уурхай" чуулга уулзалт боллоо. Энэ чиглэлээр олон төрийн бус байгууллагууд ажиллаж байна. Бид ч сүүлийн 10 гаруй жил санаачилгын чиглэлээр ажиллаж байна, үүнийг цаашид сайжруулах талаар Төрийн нарийн дарга цаашдаа анхааран ажиллахыг хүсэж байна. Бидний хийсэн 13 жилийн ажил сулрахгүй байгаасай, Монгол улс дэлхийн 52 орноос тайлагналаараа 2 дугаарт шалгарсан амжилттай ажиллаж байгаа харин төр маань хангалттай сайн ажиллахгүй байгаа тул энэ талаар салбарын сайдад уламжилна уу гэж хүсэж байна.

Б.Батболд: ОҮИТБС-ын үйл ажиллагаанд гурван талын оролцоог хангаж ажилладаг, иргэний нийгмийн байгууллагын бид идэвхтэй ажилладаг. Харин явцын дунд төрийн байгууллагуудын оролцоо маш суларсан. Одоо үдээс хойш болоход төрийн байгууллагын гишүүд бүгд яваад, ИНБ-ын хэдэн хүн л үлддэг. ОҮИТБС-ын хурлын үйл ажиллагаа сүүлийн хоёр жилийн байдлаар иймэрхүү байдалтай байгаа, төрийн байгууллагын дарга нар өөрсдөө ирэхгүй орондоо нэг мэргэжилтэн, нарийн бичгээ явуулдаг. Ирэх жил сонгуулийн жил, ажлын төлөвлөгөөг харахад ирэх 6-р сард хуулийн төсөл өргөн барихаар тавьсан байна. Энэ үед юу хуулийн төсөл, сонгууль гэвэл алга болно дараа нь орон нутгийн сонгууль гэвэл байхгүй. Тэгэхээр энэ хуулийн төслийн хугацааг урагшлуулж зохицуулах хэрэгтэй байна. Оролцох ёстой дарга нар нь идэвхтэй оролцмоор байна. Өмнө нь Ерөнхий сайдын түвшинд байхад бүгд сайдууд оролцдог байсан одоо улам сулраад иргэний нийгмийн хэдэн хүн л суугаад байдаг.. Цаашид энэ тал дээр анхаарахыг Төрийн нарийн бичгийн даргаас хүсэж байна.

Н.Баярсайхан: ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд санхүүжилт чухал байна. Санхүүжилт саатсаны улмаас хийх ёстой ажлууд хийгдэхгүй, ажлын албанд олон жил ажилласан зарим хүмүүс ажлаасаа гарах жишээтэй байна. Нэгэнт яам ОҮИТБС-ын Ажлын албыг дэргэдээ авсан юм чинь санхүүжилтын асуудлыг тогтвортой баталгаатай болгоод төсөвт суулгаад явмаар байна. Мөн сар бүрийн Ил тод уул уурхай хэвлэлийн хурал хийхдээ зөвхөн яамныхаа ажлыг ярилгүй ОҮИТБС-ын ажлын талаар танилцуулж баймаар байна. Ингэхгүй бол яамны уялдаа холбоо байхгүй байна.

Ц.Уранцоож: Жил бүр тайлан гарч, үүний дагуу зөвлөмжүүд гардаг. ИНБ-уудаас зөвлөмжийн биелэлт дээр анхаарч ажиллахыг хүсдэг. Жил бүр Гаалийн ерөнхий газрын талаар ярьж байдаг, энэ жил бас л яригдаж байна. Хамгийн их зөрүүтэй мэдээлэлтэй, тайлан мэдээгээ өгдөггүй асуудал хэвээр байна. Энэ байгууллагатай ямар арга хэмжээ тооцсон эсвэл авах гэж оролдсон талаар Сангийн яамнаас асуумаар байна.

Л.Бор: ОҮИТБС-ын эрч хүч нь саараад байна гэж хүмүүс хэллээ, санал нэгтэй байна. ОҮИТБС нь орон нутагт хүрч чадахгүй байна, төсөв хөрөнгийг нь улсын төсөвт суулгамаар байна. Цөмийн энергийн хууль болон бусад хуулиудад гэнэт өөрчлөлт ордог, үүнийг хийхдээ ИНБ-аас санал авч байх. Ер нь ОҮИТБС-аас гадна уул уурхайн салбараас болоод хүний амь эрсдсэн, хөдөлмөрийн чадваргүй болсон зэрэг талаарх мэдээлэл хэрэгтэй байна. Бид үүнийг судлаад мониторинг хийгээд явахаар биднийг хардаж сэрдээд байна. Зарим компаны охин компани гээд ямар ч үйл ажиллагаа явуулаагүй гэх боловч гаднын хөрөнгийн бирж дээр газрын доорх баялагийг барьцаанд тавьчихсан байдгийг анхаармаар байна.

Л.Төр-Од: 2021 оноос эхлээд ажлын албаны төсөв зардлыг яамны багцад суулгаж, төсөвт суулгах. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн 6.2-т оруулсан заалтыг хэрэгжүүлэх үүднээс ажлын хэсэг байгуулахыг яамнаас хүсэж байна. Манай санаачилга эрхзүйн үндсийг бүрдүүлж манлайлж ажиллах боломж байна. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын түвшинд том ажлын хэсэг гарах байх, манай санаачилгын хувьд дэд ажлын хэсэг байгуулаад түүчээлээд явах саналтай байна.

Д.Галбаатар: Өнгөрсөн оны төлөвлөгөөнд эрэн сурвалжлах сэтгүүлчтэй хамтран ажиллах ажил байсан, энэ ажил тасалдсан. Засгийн газрын хуралдаанаас уул уурхайн хяналт гэдэг асуудал нилээд яригдсан. Хэрвээ бид ОҮИТБС-ын хуулийг гаргаад, стандартыг мөрдөөд явсан бол бид ингэж явахгүй байсан. 2016 онд Сангийн яам Эрдэс баялагийн ашигтай металыг тооцох стандартыг баталсан. Нэг тонн металлаас зардлыг нь хасаад цэвэр металыг капиталжуулна гээд заасан, үүнийг манай яам яагаад хийхгүй байна? энэ маягтад ордын нөөц гэсэн зүйл яагаад яригдахгүй байна? Оюутолгойн нөөц гэхэд олон юм ярьж байна, Монголын иргэд дэлхийн түвшинд эрдэс баялагийн хөрөнгийн үнэлгээний арга боловсруулсан байна. Манай УУХҮЯ Австралитай нийлээд үнэлгээг хийсэн байгаа үүнийг Засгийн газар яагаад бодлого болгоод ажиллаж болохгүй байна. Бид байгалийн нөөцөө үнэлж байж цааш явна, Оюутолгой байгалийн нөөцийн хорогдол гээд нөөцөө хорогдуулаад явж байна. Бид энэ аргаар Эрдэнэтийн 51 хувийг ашгийг авдаг болсон. Яагаад энэ үйлдвэр аж ахуйн газрууд , гаднын туршлага, иргэдийн ярьж байгаа зүйлийг нэгтгэж зангидаад авч чаддагүй төртэй болсон юм бэ? ОҮИТБС, иргэний нийгэм маш их зүйлийг хийсэн. Одоо 60 гаруй хувь нь ОҮИТБС-ын тайлангаа өгөөд бусад 30 гаруй хувь нь өгөхгүй байна. Манай салбарын орлого ДНБ-ий 40 гаруй хувийг эзэлдэг, ингэж ажиллахгүй ээ. Түрүүн дурдсанаар уламжлалт ёсоо дээдлээд, чаддаг мэддэг хүмүүсээ ажиллуулмаар байна, муу хийсэн учраас энэ ажлыг гудамжинд гаргасан гэж үзэж байна.

Г.Нандинжаргал: Та бүхний хэлснийг хүлээн зөвшөөрч байна. Манай санаачилга дэлхийд хоёрдугаарт явж байгаа нь та бүхний хийсэн ОҮИТБС-ын тайлангийн үр дүн юм. ОҮИТБС-ын талаар ийм байгууллага байдаг та нар хамтран ажиллаж зөвлөгөө өгөөч гэхэд үгүй гэх асуудал байдаггүй. Би Ажлын хэсгийн хурлаа улиралд нэг удаа, өөрийн өрөөнд зохион байгуулж ажиллана. Салбарын хууль тогтоомжид та нарын хийсэн зүйлээс оруулна, Үндсэн хуульд нийцүүлэн хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулна. Он гараад Дамба дарга ажлын хэсгийг ахалж ажиллана, мэргэжлийн хүн байгаа. Би энэ уулзалтыг АТГ-тай хамтран хийх саналтай байсан, он гараад хамтдаа хийх байх. Энэ хурал дээр гарсан бүх асуудлыг тэмдэглээд сайдад танилцуулна. Дараагийн удаа сайд нараа авч ирнэ. Ингээд би Засгийн газрын ажилтай тул Дамба дарга хурлаа үргэлжлүүлэн удирдана.

Д.Дамба: Би УУХҮЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга, даргын чиглэл болгосны дагуу өнөөдрийн хуралдааныг удирдан явуулна.

1. **ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОҮИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлангийн төсөл**

Л.Баярцогзол: Бид ОҮИТБС-ын 2018 оны 13 дахь удаагийн нэгтгэл тайланг 11 дүгээр сард ОҮИТБС-ын ажлын хэсгийн хуралдаанаар танилцуулаад, гишүүдээс санал зөвлөмжийг аваад, үүний дагуу засаж, сайжруулан өнөөдрийн байдлаар тайлангийн монгол хувилбар бэлэн болоод байна. Засгийн газрын тайлангаар 1986 компанийн 2,1 их наяд төгрөгийн орлого тайлагнагдсан, компанийн тайлангаар 1490 байгууллагын 2,9 их наяд төгрөгийн орлого гаргасан байна. Засгийн газарт тайлангаа ирүүлээгүй компани 68, компанийн тайланд тайлангаа ирүүлээгүй 564 аж ахуйн нэгж байгааг тогтоосон. Томоохон 240 аж ахуйн нэгжийг шалгаад олборлох салбарт холбоогүй 39 компани байгааг тодорхойлсон. Тусгай зөвшөөрөл 2018 оны 12 сарын байдлаар 3447 байсан нь 2140 аж ахуйн нэгжид харъяалагдаж байна. Ажлын даалгаварт заасны дагуу нийт орлогын 98-99 хувийг хамрах байдлаар түүврээ хийгээд 2018 оны нэгтгэл тайланд 202 компани хамрагдсан. Үүнд ашигт малтмалын олборлолт эрхэлдэг 22, хайгуул эрхэлдэг 120, хайгуул болон олборлолт эрхэлдэг 51, байгалийн хий газрын тосны олборлолт эрхэлдэг 8, ашигт малтмал байгалийн хий, газрын тосны хайгуул эрхэлдэг 1 компани сонгосон. Олон талт ажлын хэсгийн саналын дагуу сонгож авсан 8 компани нь талбайн хэмжээ том, бага татвар төлсөн компаниуд байсан.

Нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын анхны зөрүү 110,8 тэрбум төгрөг байсан энэ нь нийт орлогын 4%-тай тэнцэж байна. Тохируулгын дараах зөрүү өнөөдрийн байдлаар 279 сая төгрөг буюу 426,9 сая төгрөгийн эерэг зөрүү, 150,7 сая төгрөгийн сөрөг зөрүүгээс бүрдэж байна. Үүнээс хойш Гааль, төрийн байгууллага компаниудаас авсан мэдээллийг нотлох баримтаар баталгаажуулсны эцэст зөрүүгээ 279 сая төгрөг болтол бууруулж чадсан байгаа. Гаалийн ерөнхий газар, халамж үйлчилгээний төв, аймгуудын Засаг даргын тамгын газар зэрэг төрийн байгууллагуудын зөрүү тохируулагдаагүй үлдсэн байна. Компаниудийн хувьд томоохон зөрүүтэй үлдсэн компани нь Эрдэнэт, Монгол алт, Таван толгой, Энержи ресурс гэсэн компаниуд байна.

Бенефициар өмчлөгчийн талаарх мэдээллийг нэгтгэлд хамрагдсан 202 компанид хүргүүлсэн боловч 60 орчим компани л мэдээллийг ирүүлсэн, цаашид сайжруулах талаар зөвлөмжид тусгасан. Гэрээний ил тод байдал, бенефициар өмчлөгчийн талаарх мэдээлэлд ахиц дэвшил гарч байгаа. Мөн бүтээгдэхүүн хуваах гэрээний хүчин төгөлдөр байгаа гэрээний жагсаалтыг тайланд харуулсан.

Монгол улсын олборлох салбарын статистик, тойм мэдээллийг дэлгэрэнгүй оруулсан мөн төрийн оролцоо, төрийн өмчит компани, төрийн оролцооны хувь, нөхөн сэргээлт зэрэг мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээлэл зэргийг хавсралт мэдээллээр оруулсан. Өмнөх ажлын хэсгийн хурлын талаар өгсөн саналыг хэрхэн тусгасан талаарх мэдээллийг оруулсан. Баяжуулах салбарын талаарх мэдээллийг оруулах байсан боловч мэдээлэл ирүүлээгүй. 2018 оны нэгтгэл тайланг хийхэд гарсан хүндрэл бэрхшээлийн талаар төрийн байгууллагууд мэдээллээ өгөхгүй байх, дутуу өгөх, шаардсан мэдээллийг ирүүлэхдээ хугацаа алдах, төрийн байгууллагууд ач холбогдол өгөхгүй байх, гаргасан мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байх, Засгийн газрын яам агентлагуудын цахим тайланд оруулсан мэдээлэл буруу эсвэл дутуу дүнгээр тайлагнасан байх зэрэг хүндрэл гарсан.

Нэгтгэл тайлангаар Цахим тайлангийн мэдээллийн системийг улам боловсронгуй болгож тайланд шаардлагатай бүх мэдээллийг оруулах, ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийн сан нь хүчин төгөлдөр эсэхийг нягталж байх, олон талт ажлын хэсгийн бүрэлдхүүнд жендерийн тэнцвэрийг хангахын тулд оролцогч тал бүрийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийж, арга хэмжээ авах, ОҮИТБС-ын дэд зөвлөлийг санхүүжилтийг шийдвэртэй холбоотой Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах талаар ажиллах, тайлангийн маягтыг сайжруулах, ашиг хүртэгч эздийн мэдээллийг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг өгсөн байна. /Тайлангийн төсөл, танилцуулгыг хавсаргав/

Д.Дамба: Энэ удаагийн тайлан өмнөх тайлангуудаас ямар онцлог, шинэлэг тайлан болсон бэ?

Л.Баярцогзол: 2018 оны тайлан нь шинэ стандартын дагуу хийгдсэнээрээ онцлог байгаа. ОҮИТБС-ын стандартын дагуу шинэлэг байдлаар хийсэн, мөн нилээд олон мэдээллийг стандартыг баримталж нэмж оруулсан нь өмнөх тайлангуудаас онцлог болсон байх гэж бодож байна.

Т.Мөнхбат:Оюутолгойн тухайн жилийн төлсөн төлбөрүүдийг тайланд харуулсан боловч гэрээт компаниудын мэдээлэл орохгүй байна. Тусгай зөвшөөрөлгүй компаниудын олж байгаа ашиг орлого тайланд ямар байдлаар тусаж байна?

н.Буяннэмэх: Зөвхөн Оюутолгой компанийн мэдээлэл орсон, туслан гүйцэтгэх компанийн мэдээлэл ороогүй байгаа.

Г.Уранцоож: Тайлан өгсөн компаниудын талаарх мэдээллийг оруулсан байна, тайлангаа өгөхгүй байгаа компаниудын талаар зөвлөмж өгсөн үү? Өнгөрсөн оны тайлангийн зөвлөмжид мониторинг хийсэн гэсэн, Гаалийн ерөнхий газрын талаарх асуудал өнгөрсөн тайлангуудад яригдаж байсан, энэ жил мөн яригдаж байна, энэ талаар хэрхэн зөвлөмж өгсөн бэ? цаашид яах вэ гэдэг талаар асуумаар байна. Гуравдугаарт, тайланд жендерийн талаар мэдээлэл оруулсан байна, маягтан дээр насны мэдээллийг оруулсан байсан үүнээс гадна хүйс гэж оруулмаар байна.

н.Буяннэмэх: Өнгөрсөн жилийн тайлангаар Гаалийн ерөнхий газрын зөрүү их байсан талаар оруулсан байсан. Гаалийн ерөнхий газрын талаар нарийн оруулаагүй зөвхөн Засгийн газрын тайлангийн мэдээллийг сайжруулах талаар зөвлөмж оруулсан байгаа. Жендерийн талаар бэлтгэсэн маягтын дагуу тайланд оруулсан.

Г.Уранцоож: Жил бүр адилхан зөвлөмж өгөөд байхаар үр дүнгүй, Гаалийн ерөнхий газартай хэрхэн хариуцлага тооцох, ажиллах талаар нарийн зөвлөмж тусгах хэрэгтэй байх.

Н.Баярцогзол: Зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнахад ГЕГ нааштай болж байгаа гэдэг байдлаар тайлагнасан гэхдээ энэ жил ч бидний ажилд хүндрэл гарсаар байгаа, бид таны саналыг тусгаж аваад эцсийн тайландаа оруулъя.

Н.Баярсайхан: Засгийн газрын хүлээн аваагүй татвараа тайлагнасан нөгөө талдаа компани төлөөгүй татвараа тайлагнасан гэдэг ямар учиртай вэ үүнийг тайлбарлаж өгнө үү? энэ хоёр дээр маш том дүн харагдаад байна, ойлголтоо нэгтгэх хэрэгтэй байна. Нөхөн олговороор олгосон лицензийн мэдээллийг компанийн нэрээр гаргах боломжтой юу, нөхөн сэргээх ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн буюу нөхөн сэргээлт огт хийгээгүй компаниудын судалгаа гэсэн мөртлөө аймгуудын талбайн хэмжээ байна, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл хавсралтаар орж байгаа юу?

н.Буяннэмэх: Засгийн газрын хүлээж авснаа тайлагнаагүй гэдэг нь цахим системд мэдээллээ шивээгүй гэсэн агуулгатай адил. Үүнд хоёр байгууллага байсан, Эрдэнэт үйлдвэрийн 35 тэрбум, цахилгаан шугам сүлжээний компани 43 тэрбум төгрөгийн орлогоо цахим системд тайлагнаагүй байсан. Компаниудын талаарх мэдээллийг нэмэлт тодруулга маягтаар оруулсан. Нөхөн олговрын талаарх мэдээллийг нэмэлтээр хавсралтад оруулах боломжтой. Нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг БОАЖЯ маягтаар, тусгай зөвшөөрөл болгоноор дэлгэрэнгүй гаргаж өгсөн, хавсралтаар компани бүрээр дэлгэрэнгүй орж байгаа, энэ нь 2018 оны мэдээлэл юм.

Б.Баярмаа: Аудитын компанид баярлалаа, богино хугацаанд их ажлыг амжуулж хийсэнд баярлалаа. Зөрүүг үүсгээд байгаа газруудад тус тусад нь зөвлөмж өгмөөр байна. Хамгийн их зөрүү гаргаж байгаа байгууллагуудад төрийн өмчит компаниуд байгаа нь сонирхол татаад байна. Зөрүү нь ямар учир шалтгааны улмаас гарч байна, байгууллагын удирдлагатай холбоотой байна уу, ашиг сонирхолтой холбоотой байна гэдгийг тогтоосон уу? үүнд нөлөөлж байгаа тодорхой нөхцөл, хүчин зүйлийг нь тодорхой харж чадсан уу? Бенефициар өмчлөгчийн мэдээллийг 60-хан компани мэдээллээ өгч байгааг хариуцлагагүй байна гэж үзэж байна.

Тайлангийн зөвлөмжид хариуцлага тооцох талаар хатуу сануулга зөвлөмж өгч байна уу? Стандартын шаардлага болгонд асуудал болгонд ямар сайжруулах талаар ямар зөвлөмж өгсөн бэ?

Н.Буяннэмэх: Таны саналын дагуу зөвлөмжөө улам дэлгэрэнгүй тодорхой болгоё. Төрийн өмчит компаниудын тайлангийн зөрүү нь Гаалийн байгууллага болон халамжийн байгууллагад гарсан. Компаниуд бид ийм татвар төлсөн гэзд гаргасан гэтэл төрийн байгууллагууд хүлээн авсан төлбөрийг тайлагнасан боловч эдгээр дүнгүүд нь хоорондоо таарахгүй зөрүү гарсан, цаг хугацаа бага байсан болохоор томоохон дүнгүүдийг тааруулаад жижиг зөрүүнүүд тохируулагдаагүй үлдсэн байгаа.

Л.Баярцогзол: Бенефициар өмчлөгчийн талаарх мэдээллийг сайн дураар гаргаж байгаа, үүнд хуулийн зохицуулалт шаардлагатай байна. Бид зөвлөмжийг өгнө, үүний дагуу Уул уурхайн яам арга хэмжээ авах хэрэгтэй байх.

Б.Баярмаа: Лиценз шилжүүлэлтийг хэнээс хэнд шилжсэнийг гаргасан уу? хуулийн дагуу лицензээ шилжүүлээд татвараа төлж байна уу гэдгийг гаргаад өгвөл бидэнд хэрэгтэй байна.

Эрдэнэсан: Тайланд оруулсан мэдээллийг ямар байгууллагын эх сурвалжаас авсныг заавал оруулах ёстой. Гаалийн ерөнхий газрын мэдээллийг авсан бол гаалийн эх сурвалжаас гэх мэт тодорхойлж байх зайлшгүй шаардлагатай. Тайлангийн 120 дугаар хуудсанд ДНБ-ийг харуулсан байна. Энэ хүснэгт өөрөө буруу хүснэгт байна, үүнийг шалгаж зөв гаргамаар байна. Уул уурхайн яам, Сангийн яам болон Үндэсний статистикийн хорооны мэдээлэл ялгаатай байна гэж байна. Олборлох салбартай холбоотой статистикийн мэдээллийг УУХҮЯ-нд төвлөрүүлэх хэрэгтэй. Эдгээр мэдээллийг хянаж шалгасны дараа бусад байгууллагуудад өгөх ёстой гэж үзэж байна. Хэрвээ УУХҮЯ статистикийн нэгжтэй бол мэдээлэл авч, мэдээллийн сангаа бүрдүүлдэг байх хэрэгтэй. Манай статистикийн байгууллага анх байгуулагдсанаас хойш уул уурхайтай холбоотой бүхий л мэдээллийг өнөөг хүртэл цуглуулсаар ирсэн. Яг ямар мэдээлэл зөрөөд байгааг тодорхой болгох, үүний дагуу арга хэмжээ авмаар байна. Төрийн байгууллагууд нэгдсэн тоогоор мэдээ тайлангаа гаргадаг байх ёстой, ийм зөрүүтэй мэдээлэлтэй гэсэн асуудал байж болмооргүй байна. Ямар мэдээлэл ямар урсгалаар хаанаас ирсэн, ямар учраас зөрүү гараад байна гэдэг шалтгааныг олох хэрэгтэй. Тайлангийн мэдээлэл буруу дүн, тоотой баймааргүй байна, үүнийгээ засаарай.

Д.Цэрэнжав: Тайлангийн хавсралт том хэмжээний мэдээллийг боловсронгуй болгож оруулахыг хүсэж байна. Жилээс жилд тайлан сайжирч байгаа, анхны тайлангаар 93 тэрбум төгрөгийн зөрүү гарч байсан бол одоо 276 сая төгрөгийн зөрүү тохируулагдаагүй байна. Өмнө нь тайлан гаргаад хэнд яаж хүргэх вэ гэдэг асуудал байсан бол одоо нийгэм цаг үе өөрчлөгдсөнөөр мэдээллийг ямар хэлбэрээр ашиглах вэ гэдэг нь чухал болсон байна. Одоо хүмүүс мэдээлэл өгөгдөлтэй их ажилладаг болсон байна, залуучууд өөрсдөө мэдээллийг ашиглаад дүгнэлтээ хийдэг болсон байна. Мэдээллийн зөрүүтэй байдлын шалтгааныг олох, зөвлөмж өгөх хэрэгтэй зэргээр санал гаргаж байна. Энэ нь нарийн гарах боломжгүй, харин тайланд ашиглаж байгаа өгөгдлөө дэлгэрэнгүй өгвөл бид өөрсдөө тэндээс дүгнэлт хийх боломжтой юм. Одоо дүгнэлтийг олон хэлбэрээр гаргаж байна, орон нутгаар нь, асуудлаар нь гэх мэтээр. Хавсаргах өгөгдлөө сайн өгөхөд анхаарлаа хандуулаарай.

Л.Төр-Од: Төрийн албаны сахилга батад ихээр анхаарал хандуулж байгаа. Тайланд орох мэдээллээ өгөхгүй байгаа төрийн байгууллага, компаниудад ямар хариуцлага тооцох талаар Үндэсний зөвлөлийн хуралдаанаас зөвлөмж гаргах санал байна. 2887 тусгай

зөвшөөрөлд шалгалт хийсэн байгаа үүнээс ямар зөвлөмж дүгнэлт гарсныг олж, үүнтэй ажлаа уялдуулмаар байна. Зөвлөмжийн хэрэгжилт дээр Ажлын хэсэг, дэд хэсэг гаргаж хяналт шинжилгээ хийж ажиллах саналтай байна.

Л.Бор: Цаашдаа тусгай зөвшөөрөлтэй газрыг 2 дахин нэмэгдүүлэх боломжтой гээд байдаг. Манайх шиг усны хомсдолтой бараг 80 хувь нь цөлжсөн газар болмооргүй байна. Үүнийг анхаарч ажиллаарай.

Д.Галбаатар: Тайлан бол хангалттай түвшинд хийгддэг болсон. Тайлан сайн байдаг гэдэг нь маягт хэрхэн зөв байхаас шалтгаална. Цаашдаа орчуулга дээр анхааараарай, тайлангийн харьцуулалтыг сайн хийх хэрэгтэй. ОҮИТБС-ын тайлангаар олон нийтэд зөв мэдээллийг өгөх боломжтой, зарим нэг нь хэн хийдгийг ч мэдэхгүй л байгаа, суртчилах ажлаа муу хийж байгаа гэдгийг хэлье. Эрдэнэт үйлдвэрийн 31 сая төгрөгийн асуудал яригдаж байна. Энэ нь манай зардлын10000-ны 2 хувийг эзэлнэ, "томын зовлон" гэж байна. Эрдэнэт хамгийн их татвар төлдөг зөвхөн АМНАТ-аар жилдээ 300-400 тэрбум төгрөг төлдөг.

Б.Батболд: Шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээллийг ил болгомоор байна. Хэн хэн ямар лицензийг хэдэн төгрөгөөр ямар эх үүсвэрээр авсан гэдгийг тодорхой болгомоор байна. БДО тусгай зөвшөөрлийн шилжилтийг хавсралтаар гаргаж тайланд оруулмаар байна.

Н.Баярсайхан: Тайлангийн хавсралтын хэмжих нэгжийг ойлгомжтой байхаар нягталж хараарай. Зөвлөмжийг зөвхөн хийж байгаа ажлынхаа даалгаврын дагуу өгдөг, ОҮИТБС нь стратеги төлөвлөгөөтэй үүнтэй уялдуулан арай том зургаар харж стандарт шаардлагад нийцүүлээд хийгээрэй. Мөн зөвлөмжийг төрийн байгууллагад хандсан, орон нутагт хандсан байдлаар чиглүүлж өгвөл дараа нь мониторинг хийхэд илүү дөхөмтэй юм. Түүнчлэн зөвлөмжийг дандаа ёстой гэж төгсгөсөн байна. Найруулга дээрээ үүнийг анхаарна уу.

Д.Дамба: Хуралдаанд идэвхтэй оролцож санал зөвлөмж өгсөн гишүүддээ баярлалаа. Дэгийн дагуу эхний асуудлын шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя. Консерцум гэдэг үг хэллэгийг авах нь зөв байх, хураангуй гэдэг үгийг хасах, мөн гуравдугаар заалтыг хасах саналтай байна.

Д.Цэрэнпүрэв: Оролцогч талууд гэдэгт Дэд зөвлөл гэж оруулмаар байна.

Д.Дамба: Болно, тайлангаа гаргаагүй компаниудад авах арга хэмжээг тодорхой болгох нь зүйтэй байх. Зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийх, гүйцэтгэлийн аудит хийх гэдэг байдлаар томъёолох нь зүйтэй болов уу.

Н.Баярсайхан: МХЕГ тайлан гаргаагүй компаниудыг торгож байгаа, үүнийг хэдэн компанийг хэдээр торгосон гэсэн мэдээллийг оруулах санал байна.

Д.Дамба: Тусгай зөвшөөрлийн огноо ил болгох гэдэг дээр өөр бусад мэдээллийг ил болгохоор нэмж оруулах санал байна. Тухайлбал, шилжсэн тусгай зөвшөөрлийн мэдээлэл гэх мэт. Мэдээллийг олон нийтэд суртчилах ажлыг зөвлөмж болгосон нь зөв байх гэж харж байна. Өөр саналтай гишүүн байна уу?

Л.Бор: Тусгай зөвшөөрлийн газрын хэмжээг нэмэгдүүлэх тухай зөвлөмжийг хасуулах саналтай байна.

Д.Дамба: Миний ойлголтоор оноос өмнө хайгуулын зөвшөөрлийг олгох асуудлыг зогсоох байх, саяхан Төрийн нарийн бичгийн дарга ч тэмдэглэн хэлсэн байгаа. Энэ асуудал Улсын их хурлын түвшинд яригдаж байгаа, оноос өмнө шийдвэр гарчих байх.

Б.Батболд. Дараагийн ажлын хэсгийн хуралдаанд тайлангийн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ, даалгасан даалгаврын талаар тайлагнах саналтай байна.

Д.Дамба: Шийдвэрийн хамгийн сүүлийн дугаар энэхүү гарсан зөвлөмжид хяналт тавьж ажиллахыг тодорхой субъектэд үүрэг өгөх замаар тусгаж оруулна, хугацаатай үүрэг өгсөн ч болно. За ингээд үдээс өмнөх хуралдаандаа идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа

2. **ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монголын ОҮИТБС-ын 2019 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийн явц, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай**

Ш.Цолмон: Өмнөх ажлын хэсгийн хуралдаанаар дэлгэрэнгүй танилцуулсан байгаа, ЕСБХБ-ны санхүүжилт орж ирснээр зарим төлөвлөсөн ажлууд хийгдэж, нийт 2019 онд нийт 40 ажил төлөвлөснөөс 15 ажил хийгдэж, биелэлт 45 хувьд хүрсэн байна. 2019 онд санхүүжилт саатсаны улмаас нилээд ажил хийгдээгүй дараа жилийн төлөвлөгөөнд шилжсэн байгаа. ОҮИТБС-ийн тайлан гаргаагүй 500 орчим компани байгаа, эдгээрийн нэрсийг МХЕГ т хүргүүлж Зөрчлийн хуулийн дагуу арга хэмжээ авах байх. Эргээд МХЕГ үр дүнг Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулах юм.

2020 оны ажлын төлөвлөгөөнд 49 дүгээр хуралдаанаас гарсан гишүүдийн саналыг нэмж оруулсан, гишүүдээс уриа байх хэрэгтэй, үүний дагуу зорилтоо биелүүлэх чиглэсэн ажлуудыг хийх санал гарсан байна. Үүний дагуу Дэд зөвлөлийн чадавхижуулах жил болгохоор болж, зарим ажлуудыг нэмж оруулсан байгаа. Тухайлбал, төлөвлөгөөний 10.2 болон 10.5 д ажлуудыг нэмж оруулсан. Нэгтгэл тайлангийн зөвлөмжийн дагуу 13 дугаар зорилтоор хийгдэх ажлуудыг нэмж оруулсан. Зорилт 12 дугаарт ОУ-ын газраас өгсөн зөвлөмжийн дагуу 2021 оны баталгаажуулалтад бэлтгэх ажлын хүрээнд хийгдэх ажлуудыг оруулсан. Өнөөдрийн хуралдаанаар Төрийн нарийн бичгийн дарга Ажлын хэсгийн хуралдааныг сайжруулах, уулзалт зохион байгуулах замаар ажлыг сайжруулах чиглэл өгсөн, ажлын албаны зүгээс баяртай байна.

Д.Дамба: За баярлалаа,гишүүдээс танилцуулгатай холбогдоод асуулт, саналаа нэгтгээд хэлж болно.

Б.Баярмаа: Ирэх жил сонгуулийн жил болно, намуудын дарга нар, орон нутгийн удирдлагуудтай уулзаад хуулийн төслийн саналаа мөрийн хөтөлбөрт нь оруулах талаар ажлын албанаас санаачлаад ажлын хэсэгтэй хамтран хийх ажлуудыг төлөвлөгөөнд оруулах саналтай байна.

Б.Батболд: Хуулийн төслөө хаврын чуулганаар батлуулах арга хэмжээ авмаар байна. Хэрвээ хавар чадахгүй бол сонгуулийн дараа шинэ хүмүүстэй уулзаж, танилцуулах гэж цаг алдана. Иймд хуулийн төслийн асуудлаа 2 сар гарангуут эхлэх хэрэгтэй байна.

Н.Баярсайхан: Эхлээд 2019 оны төлөвлөгөөний биелэлтээ дүгнэж шийдвэрээ гаргачихаад, 2020 оны төлөвлөгөөгөө ярилцах саналтай байна. Энэ оны төлөвлөгөөний 9.6 дээр Ханбогд суманд очиж Дэд зөвлөлийн туршлага судлах гэсэн ажил байна, энэ өмнө нь байсан уу? Энэ ажлыг 2020 оны төлөвлөгөөндөө оруулах саналтай байна. Яагаад заавал Ханбогд гэсэн юм бол, бид Заамар, Ерөө, Гурвантэс зэрэг 5 сумдад хөрөнгө мөнгө зарцуулаад Дэд зөвлөлийг дэмжиж ажилласан, чадавхижуулсан, мэдээллийн ажилтан ажиллаж байгаа учраас эдгээр сумдаас туршлага судлах нь илүү зүгээр байх. Ханбогд сумын хувьд гомдол гаргасан иргэдтэй яаж ажиллах вэ гэдэг дээр илүү туршлагатай ажиллаж байна. Өмнө нь 2008 оноос эхлээд 6 жил Дэд зөвлөл ажиллаж байсан, гэхдээ ганц том компанитай газар Дэд зөвлөл

ажиллах боломжгүй юм байна гэж харсан. Иймээс Ханбогдыг арай өөр сум болгоод дараа оны төлөвлөгөөнд тусгах санал байна. Бидний саналыг тусгаад 2020 оны ажлын төлөвлөгөөг "Шинэ стандартыг суртчилах, дэд зөвлөлийг чадавхижуулах" жил болгохоор оруулсан байна. 2016 онд Дэд зөвлөлийн чадавхижуулах жил болгох зорилт тавьж байсан, зорилтоо хэрхэн биелүүлэх талаар тодорхой ажлуудыг тусгахгүй бол зорилт биелэгдэх боломжгүй болно. Тухайлбал, УУХҮЯ наас ямар шийдвэр гаргуулах, Үндэсний зөвлөлийн хуралдаанаас ямар ажлуудыг хийх зэргийг тодорхой оновчтой болгомоор байна. ТАН эвслийн хувьд Дэд зөвлөлийг чадавхижуулах тал дээр нилээд туршлага байгаа. Баяжуулах үйлдвэрийн маягтыг боловсруулаад мэдээллийг авах шаардлагатай байна. Баяжуулах үйлдвэрийг хэд нь өөрсдөө олборлож байна, хэд нь худалдаж аваад ажиллуулж байна гэдгийг ил тод болгохгүй бол олборлох салбараа цогцоор нь ил тод болгож чадахгүй байна. Ажлын хэсгийн хурал дээр зарчмын хувьд тохирсон. Иймээс 2020 оны төлөвлөгөөндөө баяжуулах үйлдвэрийг ил тод нээлттэй болгох маягт боловсруулах ажлуудыг оруулах саналыг өнөөдрийн хуралдаанаас шийдэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Д.Галбаатар: Аймгуудын Дэд зөвлөлтэй хэрхэн ажилласан бэ, ямар холбоотой байна вэ? Сонгуулиас хойш бүр байхгүй болсон байх. Төрийн нарийн бичгийн дарга хэлэхдээ Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулна гэсэн. Ажлын хэсэг мэдээллийн сантай болох хэрэгтэй, мониторинг хийх хэрэгтэй. Яамаар дамжуулан аймгуудын Дэд зөвлөлийг ажилтай болгох хэрэгтэй, хөдөө орон нутагт идэвхтэй ажилладаг олон байгууллагууд байгаа. Манай Эрдэнэт үйлдвэр олборлох, боловсруулах, баяжуулах бүх ажлыг цогцоор нь хийдэг. Иймээс тэр ажлын хэсэгт томоохон эрдэмтэн судлаачдыг оролцуулах саналтай байна. Дараагийн асуудал, санхүүжилт цаашдаа хэр баталгаатай байна вэ, үүнийг хэн дүгнэж хянаж байна вэ? 2019 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг харахад 45 хувьтай муу үнэлэлт авахаар байна. Ажлын алба маш сайн ажилласан харин төрийн байгууллагууд муу ажилласан.

Ш.Цолмон: Орон нутагтай холбоотой байгаа, удирдлага, хариуцсан мэргэжилтнүүд их солигддог. Үүнтэй холбоотой дахин танилцуулах, ойлгуулах сургалт хийх зэрэг шаардлагатай болдог. Харамсалтай нь 2019 онд санхүүжилт саатсан учраас ямар ч ажил хийгдээгүй, ЕСБХБ Сангийн яамтай гэрээ байгуулж 4 сарын санхүүжилт өгөхөөр тохирсон боловч санхүүжилт нь хугацаа алдаж орж ирсэн. Азийн хөгжлийн банктай гурвалсан гэрээ хийсэн гол хийгдэх ажлууд 2020, 2021 онд байгаа. Харин хийгдэх ажлуудаа оны эхэнд сайн төлөвлөхийг чиглэл болгосон. Ирэх оны төлөвлөгөөг АХБ-д хүргүүлсэн, өнөөдрийн хуралдаанаас гарах өөрчлөлтийг хийгээд танилцуулна. Аймгуудын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар хийгдэх ажлуудыг төлөвлөгөөнд оруулах бодолтой байна.

Л.Төр-Од: Төлөвлөгөөний биелэлтийн талаар гүйцэтгэлийн хувийг гаргаж өгмөөр байна. Хэдэн төгрөг төлөвлөөд хэд нь орж ирсэн, хэдийг зарцуулсан талаар оруулвал илүү сайн байна. 2020 оны төлөвлөгөөнд уриагаа оруулсан байгааг орон нутгийг чадавхижуулах гэж нэмж оруулах саналтай байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн олон байгууллага, компани, иргэний нийгмийн байгууллага байгаа, эдгээрийн ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байна. Төлөвлөгөөний хариуцах байгууллага дээр оролцогч талуудыг идэвхтэй оролцуулах хэрэгтэй байна. Манай Иргэний нийгмийн байгууллагууд сурталчилах, сургалт явуулах зэрэг ажлыг хийх боломжтой. ИНБ-ууд хөдөө орон нутагт салбартай, холбоотой байдаг учраас үүрэгжүүлж оролцуулах хэрэгтэй байна. Ажлын албанаас боловсруулсан баримт бичгийг ойлгомжтой болгох, санхүүжилт төсөв хөрөнгийг зөвхөн донорын санхүүжилтээс гадна бусад байгууллага хувийн хэвшил бизнесийн байгууллагаас гаргуулах замаар гурван талаасаа босгох хэрэгтэй. Мөн тэдэнтэй хамтраад, ажлаа уялдуулах, ИНБ-уудын хэрэгжүүлдэх төсөлт хамтарч зарим ажлуудыг хийх боломжтой юм.

Д.Галбаатар: Орон нутагт ганц нэг сургалт явуулах нь чухал биш, журам батлуулах, төрийн байгууллага компаниудад хэрхэн ойлгуулах талаар ажиллах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл төрийн бодлого болгож ажиллах тодорхой журмуудыг боловсруулах хэрэгтэй байна.

Л.Бор: Орон нутагт ажиллах төсөв санхүүжилтийг нэмэх саналтай байна. Би 2012 оноос хойш Сүхбаатар аймагт Дэд зөвлөл байгуулаад жил бүр аймгийн Засаг даргаар захирамж гаргуулаад тус аймгийн ОҮИТБС-ын тайланг хэлэлцүүлж, Дэд зөвлөл, орон нутгийн гэрээний талаар ажиллаж нилээн хэдэн жил чиглүүлж авч явж байна, зөндөө туршлага хуримтлуулсан байгаа. Үүнд нэг л удаа ажлын албанаас санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, бусдыг нь би өөрөө зохицуулсан. Аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Гэрэлт-Од гэж залууг УУХҮЯ-наас шагналд тодорхойлуулах саналтай байна.

н.Эрдэнэсан: Төлөвлөгөө 45 хувьтай биелсэн, гэхээр 2020 онд хийх төлөвлөгөөгөө хийх ёстой ажлаа, төсөвтөө тааруулж хиймээр байна. Төлөвлөгөөний биелэлт дээр тайлбар сайн хиймээр байна. Хэрэгжээгүй шалтгааныг оруулахгүй бол хүлээж авахад хэцүү байна.

Б.Батболд: Олон жил ОҮИТБС-т зүтгэсэн гишүүдийг урамшуулах ажлыг УУХҮЯ-яамнаас зохион байгуулах саналтай байна. Энэ салбарт 10 гаруй жил идэвхтэй ажилласан Баярсайхан гэх мэт хүмүүс байна. Мөн ОҮИТБС-ын олон удаагийн тайлан, үр дүнг нэгтгээд хөдөө орон нутгаар танилцуулах ажлыг төсөв санхүү нь байвал ИНБ-ууд хариуцаад хийх бүрэн боломжтой, мөнгөтэй болж байгаа юм шиг ойлгож байна.

Н.Баярсайхан: ОҮИТБС-ын Дэд зөвлөл байгуулах тухай 2012 оны 222 дугаар тогтоолын хэрэгжилтэд мониторинг хийж, дүрмийг боловсруулсан ч, яаж ажиллахаа мэдэхгүй, идэвхтэй ажиллахгүй байгаа. Иймээс Дэд зөвлөлийг ажиллуулахад ямар журам шийдвэр хэрэгтэй талаар эрхзүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай арга зүй, дүрэм журмыг боловсруулах оролцогч талуудын ажлын хэсэг байгуулж, би өөрөө ажиллах саналтай байна. Баяжуулах үйлдвэрийн маягтыг боловсруулахад мөн би өөрөө ахалж, мэргэжлийн хүмүүсийг багтаасан 3 талын оролцоотой ажлын хэсэг гаргаж ажиллуулах хэрэгтэй байна. Манай говьд энэ үйлдвэр олноор байгуулагдаж байна, өнөөдрийн байдлаар Даланжаргаланд 6 баяжуулах үйлдвэр байна, Айраг суманд 8 болох гэж байна.

Н.Эрдэнэцэцэг: Нүүрс ассоциац баяжуулах үйлдвэрийн ил тод байдлын маягт боловсруулах ажлын хэсэгт хамтрарч ажиллах боломжтой.

Д.Дамба: Биелэлтийн хувийг санхүүжилтийн улмаас ажил хийгдээгүй гэдэг байдлаар тайлбарлаад явуулчихмаар байна. Цаашдаа олон улсад орчуулагдаад явна, Үндэсний хэмжээнд статусаа бууруулаад яамны түвшинд болгосон энэ маань олон улсад хэрхэн дүгнэгдэх вэ гэдэг дээр бодож үзэх саналтай байна.

Н.Баярсайхан: Төсөвтөө тааруулаад хийсэн ажлаараа биелэлтээ гаргаж болох юм, мөн төсөвгүй хийгдсэн ажлууд ч байгаа байх.

Т.Мөнхбат: Байгаа юм үнэнээрээ байсан нь дээр, хөндлөнгийн аудит 45 хувьтай гэж дүгнэсэн байхад бид тэрнийг засах хэрэггүй гэж үзэж байна.

Д.Дамба: Дээрх асуудал дээр санал хураая. Салбарын хуулинд нэмэлт өөрчлөлт орохтой холбоотойгоор органик хуулиудад өөрчлөлт орохоор байгаа, үүнтэй холбогдуулаад ажлын хэсэг байгуулагдсан байгаа он гараад идэвхтэй ажиллах байх. Үндсэн хуультай уялдуулаад салбарын хуулиуд нийцээд ирэхээр тодорхой заалтуудыг уялдуулж, шигтгэж оруулна. Ингэхээр хуулиа дагалдаад дүрэм, журмууд гарна гэж ойлгож байгаа. Угаасаа бид Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилттой ажиллаж байгаа, яам болон Засгийн газрын зорилт ч ийм байгаа. Одоо санал, шүүмж, асуулт дуусан тул шийдвэрийн төслөө

батлая. ОҮИТБС-ын 2019 оны төлөвлөгөөний биелэлт, 2020 оны ажлын төлөвлөгөөний төслийг сонсож, гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов гэсэн томъёололоор санал хураая.

Ш.Цолмон:Ажлын албаны санхүүжилт саатсанаас төлөвлөгөөний биелэлт муу байгаа. Бидний энэ онд хийх хамгийн том ажил бол ОҮИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлан гаргах юм. Энэ ажил маань 2 удаа зарлаад 8 сарын 30-нд гэрээгээ байгуулаад маш богино хугацаанд хийж дуусгаж байна. Өөрөөр хэлбэл бид энэ жил тайлангүй ч байх нөхцөл байдал байсан харин яамнаас шийдмэг арга хэмжээ авч хамтран ажилласнаар энэ ажлыг амжилттай зохион байгуулж чадсан. Ер нь олон улсын хэмжээнд ОҮИТБС-ын тайлан бол ил тод байдлын амин сүнс юм гэж үздэг. Хэрвээ санал хураах гэж байгаа бол гишүүд маань энэ байдлыг ойлгож бодолцохыг хүсэж байна.

Л.Төр-Од: Манай ИНБ-ын гишүүдийн хувьд ихэнх нь Мөнхбат гишүүнтэй санал нэгтэй байна. Харин төсөв мөнгөгүйгээр хийгдсэн томоохон ажлуудыг энэ биелэлтэд оруулмаар байна. Бидэнд энэ ажил дээр хийх тоон буюу чанарын үнэлгээг хийх аргачлал хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл тайлан гаргах нь 50 хувь юм бол чанарын үнэлгээг оруулах нь зүйтэй байх.

Д.Галбаатар: Түрүүнд Баярсайхан зөв санал гаргасан. Энд бүтцийн өөрчлөлт орчихсон байна. Бүтцийн өөрчлөлт орно гэдэг чинь санхүүжилт зогсоно гэсэн үг, үүнийг тооцох арга ч байдаг. Санхүүжилт байгаа ажлуудаа оруулах, санхүүжилтгүй ажлыг чи хийгээгүй гэж дүгнэвэл энэ шиг буруу юм байхгүй. Анх бид тайлангаа гаргадаг болох зорилт тавьж байсан. Тайлангаа гаргавал ажлын 60 хувь биелэгдсэн гэж үнэлэх аргачлал зохиох хэрэгтэй байна. Тайлантай холбоотой 20 ажил тус бүрийг 1,5 баллаар үнэлээд нийт оноог гаргах харин орон нутагт нэг ажил нь хийгдээгүй байвал 0,1 гэдэг баллаар үнэлээд 3 болдог гэх мэт аргачлалаар тооцдог болох. Санхүүгийн эх үүсвэр байхгүй учраас зарим ажлууд хийгдээгүй хойшлогдсон, санхүүгийн эх үүсвэртэй байсан ажлуудыг дүгнэхэд ийм дүн гарлаа гэдэг байдлаар тайлбарлах нь зүйд нийцнэ гэж үзэж байна.

Д.Дамба: Төлөвлөгөөний биелэлтийг хангалттай гэж хүлээн авч байна. Ирэх оноос АХБ болон Улсын төсвөөс санхүүжилтээр ажиллана.

Б.Батболд: Ажлын албаны орон тоо хуучнаараа байгаа юу, нэмж хүн авах уу?

Ш.Цолмон: АХБ-ны төслийн хувьд зохицуулагч, санхүүгийн ажилтан, харилцааны мэргэжилтэн, Мэдээлэл технологийн зөвлөхийн орон тоо байгаа. Хэлэлцээр ёсоор ажлын алба байх ёстой. Байрны түрээсийн зардал болон нэгтгэл тайлангийн зардал улсын төсөвт батлагдсан. Харилцааны мэргэжилтэний сонгон шалгаруулалт явагдаж байгаа. Мэдээлэл технологийн зөвлөхөөр Мөнхбат гэдэг хүн шалгарсан. Мөн төслийн зохицуулагч гэж орон тоотой болж байгаа.

Д.Дамба: 2020 онд сонгууль болно үүний дараа манай яам энэ бүтцээр байх эсэхийг мэдэхгүй иймд яамны дэргэд ОҮИТБС-ын нэгжтэй болох зарчмын саналыг эртнээс тавих нь зүйтэй гэж бодож байна. Хэрвээ нэгжтэй болчихвол цаашид бидэнд тулгарах хүндрэл бэрхшээл, асуудлууд багасах юм. Өнөөдөр бид энэ ажлыг ажлын хажуугаар хийж байгаа, би одоо эдийн засаг хөрөнгө оруулалт судалгааны хэлтсийг ахалж байгаа, дарга нар маань итгэл хүлээлгээд ажиллаж байгаа. Хэрвээ яамны үндсэн бүтцэд бие даасан нэгж болчихвол орон тоо, цалин хөлс баталгаатай болно. Хамгийн гол нь шинэ Засгийн газрын бүтцэд оновчтой

тусгаж, батлуулчихвал ямар ч асуудалгүй бүх юм албажаад явна гэж ойлгож байгаа. Шийдвэрийн төслийн уншиж танилцуулан, гишүүд санал нэгтэй батлав.

3. **ХЭЛЭЛЦСЭН нь: ОҮИТБС-ын стандартын дагуу тайлангийн маягтыг шинэчлэх тухай танилцуулга**

Ш.Цолмон: 2007 онд анх ОҮИТБС-ын Тайлангийн маягтыг Статистикийн хороогоор батлуулан, Сангийн сайдын тушаалаар мөрдөж ирсэн. 2014 онд тайлагналыг цахимжуулсны үр дүнд тайлан гаргах компаниудын тоо нэмэгдсэн. Тайланг цахимжуулснаар цаг хугацааг хэмнэж, тайлагнал нэмэгдэж байгаа ч тайлан гаргахгүй байгаа компаниуд байсаар байна. Өнөөдөр нэмэлт мэдээллийн 16 маягтыг танилцуулж байна. Стандартын дагуу шинэчлэх тайлангийн маягтыг тараасан байгаа. Одоо 14 маягтын дагуу тайлан гаргаж байгаа, жил бүрийн тулган баталгаажуулалтад ордог компаниуд дээрх маягтаар тайлагнаж ирсэн. 2015 оны тулган баталгаажуулалтад 202 компани орсноос 169 компани, 2016 онд 213 компаниас 191 компани, 2017 онд 240 компаниас 211 компани нэмэлт мэдээллийн маягтаар тайлангаа ирүүлж нэгтгэл тайлан гарсан байна. Яагаад бүх компани гаргахгүй байна гэхээр энэ нь сайн дурын шинжтэй, бөглөөгүй байхад ямар нэгэн хариуцлага тооцохгүй, цэвэр гурван талын хамтын ажиллагааны дагуу гаргадаг юм. Эдгээр маягтыг заавал мөрддөг болгох зорилгоор танилцуулж байна.

Энэ оны 6 дугаар сард Парис хотноо зохион байгуулсан ОҮИТБС-ын 8 дугаар бага хуралдаанаас олборлох салбарыг бүхэлд нь ил тод болгох шийдвэр гарсан. 11 сард ажлын хэсгийн гишүүдэд эдгээр маягтуудыг дэлгэрэнгүй танилцуулж, санал авсны дагуу өөрчлөлт оруулж та бүхэнд танилцуулж байна. Үүнийг 2019 оны шинэ стандартын өөрчлөлтийн дагуу боловсруулан, Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хянуулан Үндэсний Статистикийн хороогоор батлуулж, 2020 оны 1 сарын 1-нээс эхлэн мөрдүүлэх саналтай байна. Маягт батлагдсанаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул, олборлолт, газрын тосны төрийн хувийн хэвшлийн бүх компаниуд тайлагнах болно. Мөн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа туслан гүйцэтгэгч, оператор компаниуд хамрагдах юм. Шинээр 4.15; 4.16 гэсэн шинэ маягт боловсруулсан. Үүнд, тухайн компанийн ашигласан эрчим хүч, нефтийн бүтээгдэхүүний мэдээлэл болон оператор туслан гүйцэтгэгч нарт зориулсан мэдээллийг оруулсан байна. Эдгээр маягтаар тайлан гаргаснаар компаниас эдийн засагт оруулж буй үр ашиг, нийгэмд оруулж буй хувь тодорхой болсноор хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх томоохон алхам болно гэж үзэж байна./Маягтыг хавсаргав/

Д.Дамба: Танилцуулгатай холбоотой саналаа хэлнэ үү.

Эрдэнэцэцэг: Нөхөн сэргээлтийн мэдээлэл дээр дүйцүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээллийг оруулмаар байна.

Д.Галбаатар: Анхны нөөцийн хэмжээ гэдгийг ашигт малтмалын нөөцийн хэмжээ гэж солиод, нөөцийн үнэлгээ гэж оруулах саналтай байна. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг заавал тавьж өгөх хэрэгтэй.

Н.Баярсайхан: Анхны нөөц нь хуучнаараа байгаад Галбаатар гуайн саналыг нэмж оруулмаар байна. Өмнөх хурал дээр хэлсэн энд ороогүй байна, ТӨК-ийн ТУЗ-ын хараат бус гишүүдийн цалин урамшууллыг оруулах хэрэгтэй байна. Нөхөн сэргээлтийн мэдээлэл дээр яамнаас авах гэсэн авч чадахгүй байгаа мэдээллийг оруулмаар байна, эсвэл тусад нь байх уу? 4.7 дээр гэрээний хүрээнд сан байгуулсан эсэх гэдгийг оруулах саналыг оруулсан, орхигдсон байна. Сум багийн түвшинд сан байгуулаад байгаа тийм учраас оруулах санал байна. 4.10 дээр Бенефициар өмчлөгчийн бүртгүүлсэн огноог оруулах санал байна. Ус ашигласан мэдээлэл дээр олборлох, боловсруулах, баяжуулах дээр ялгаатай харагдах байдлаар боловсруулж өгнө үү. Зарчмын хувьд маягтаа батлаад дараа нь сайжруулмаар байна.

Д.Цэрэнпүрэв: Маягтуудаа батлуулахаас өмнө Статистикийн хүнээр хянуулаад эдийн засгийн үг хэллэгт оруулах шаардлагатай байна. Борлуулалтын мэдээнд нийт дүнг тавиад

үүнээсээ хойшоо задрах байдлаар оруулвал мэдээлэл авч ашиглахад илүү ойлгомжтой болох юм. Сангийн талаарх мэдээллийг нарийн оруулах хэрэгтэй. Говийн оюу сан гэхэд жилдээ 5 сая долларыг зарцуулдаг гэж байгаа.

Д.Дамба: Маягтад редакцийн засвар нилээд орно. Усны мэдээлэл гэхэд ай сав, ундарга, хэмжих нэгжүүд янз бүр байдаг. Энд зөвхөн м.куб гэж эзэлхүүнээр байна. Маягтыг хэн, ямар байгууллага батлах вэ гэдэг чухал.

Б.Батболд: Маягтын олборлолт борлуулалтын мэдээлэл дээр яг юу борлуулсан гэдгийг ялгаж өгмөөр байна. Баяжуулсан юмуу? Шууд юм уу гэдгийг ялгамаар байна.

н.Эрдэнэсан: Хөрөнгө оруулалтыг улсын төсөв юмуу гадаад санхүүжилт үү гэдгийг ялгамаар байна. Мөн хөрөнгө оруулалтын төрлийг ялгах нь хэрэгтэй байна. Статистикийн хороо улсын хэмжээнд мөрдөх маягт арга зүйг манай байгууллага батална. Өмнө нь Сангийн яамтай хамтран ОҮИТБС-ын маягтуудыг баталж байсан.

Л.Төр-Од: Хавсралт маягттай холбоотой редакцийн хяналт орно гэсэн. Аудитын байгууллагын цахим сайт, холбоо барих мэдээлэл орох нь зүйтэй байх. Дотоодын хууль тогтоомжтой нийцүүлж зохицуулах шаардлагатай болно. Бенефициар өмчлөгч гэдгийг маягт дээр нэг нэрээр явах нь зүйтэй байх, энэ маягтанд хоёр янзаар тайлбарласан байна. Овог нэр гэдэг дээр ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр гэж оруулах нь зүйтэй байх. Оршин суугаа хаягт гэрийн хаягийг стандартын дагуу оруулсан нь зүйтэй байх. Улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг нь хэнийг хэлж байгаа гэдгийг ойлгомжтой болгомоор байна. 20-оос дээш хувийн саналын эрхтэй гэдгийг арай доошлуулах саналтай байна. Хувьцаа эзэмшлийн хувийг бас арай багасгамаар байна. Өөрөөр хэлбэл 1 хувийн санал ч давамгайлах боломжтой байдаг. Мөн маягтын 2.5-ын С-г харах хэрэгтэй байна.

н.Эрдэнэсан: Маягт зарчмын хувьд өөрчлөгдөхгүй, доторх үг хэллэг хянагдана. Зөвхөн дан ганц маягт батлагдахгүй үүнийг дагаад бөглөх заавар гарах ёстой.

Д.Галбаатар: Нөөцийн үнэлгээ маш нарийн аргачлалтай үүнийг шууд бөглөх боломжгүй. Манай яам Австраличуудтай хамтраад ордын үнэлгээг яаж хийх вэ гэдэг журмыг боловсруулсан. Үүнийгээ загвар болгоод аргачлал, журмыг баталсны дараа энэ маягт хүчин төгөлдөр болно.

Л.Төр-Од: Ер нь тайлан нэгтгэлээ хэлэлцэж байх явцад маягтыг бөглөх заавар аргачлалыг боловсруулах нь зүйтэй. Үндэсний зөвлөл томоохон бодлогын түвшинд шийдвэр гаргах, техникийн шинжтэй асуудлыг ажлын хэсгээр илүү цаг гаргаад хэлэлцэж байх саналтай байна.

Д.Дамба: За баярлалаа, хэлэлцсэн асуудалтай холбогдуулаад шийдвэрийн төслийг танилцуулъя.

Н.Баярсайхан: Техникийн ажлын хэсэг байгуулах тухай шийдвэрийн төсөлд оруулах саналтай байна. Мөн ТУЗ-ын хараат бус гишүүдийн урамшууллыг ил болгох талаар одоо шийдмээр байна.

Б.Батболд: ТӨК-ийн Удирдах зөвлөлд ИНБ-аас хүн авна гээд сургалт хийсэн, бид материалаа өгсөн боловч авдаггүй. Харин тэнд төрийн байгууллагын жижиг дарга нар орсон байдаг, тэндээс өндөр урамшуулал авдаг дээр нь төрөөс цалингаа авдаг. Тэгэхээр үүнийг ил болгох хэрэгтэй байна.

Д.Дамба: Энэ асуудал байж болно, Шилэн дансны тухай хууль, Зөрчлийн тухай хууль гэж байгаа үүний дагуу ил тод болгох боломжтой гэж ойлгож байна. Баярсайханы саналын дагуу ОҮИТБС-ын ажлын хэсгийн хүрээнд техникийн ажлын хэсэг байгуулах замаар маягт, зааврыг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулахыг үүрэг болгосон

заалтыг шийдвэрийн төсөлд нэмж оруулах саналтай байна. Эсвэл хоёр тусдаа заалт болгож оруулж болно.

Н.Баярсайхан: Ажлын хэсэг гэвэл ямар вэ?

Д.Дамба: Техникийн ажлын хэсэг гэсэн нь илүү оновчтой байх яагаад гэвэл нарийн мэргэжил шаардсан олон хавсралт, заавар боловсруулах байгаа. Төр-Од гишүүний хэлсэн саналыг дэмжиж байна. Бенефициар өмчлөгч гэхээр олон улсын түвшинд ойлгоно. Харин бид ашиг хүртэгч эзэн, эцсийн өмчлөгч гэж яриад байгаа. Үүнийг дотроо нэг ойлголтоор болгомоор байна. Хаалтанд бенефициар өмчлөгч гэж бичих үү гэсэн санал байна.

Н.Баярсайхан: Үүнийг бид Үндэсний зөвлөлөөрөө шийдвэр гаргачихмаар байна. Хуулинд хоёр янзаар яваад байгаа, хууль өөрчлөхийг хүлээвэл цаг хугацаа алдана. Тийм учраас ойлголтоо нэг болгоод бусад талуудад суртчилаад явахад болохгүй юм байхгүй гэж бодож байна.

Д.Дамба: Ажлын хэсэг нь удирдамжийн дагуу ажлаа хийнэ гэж ойлгож байгаа. За ингээд шийдвэрийн төслөө батлая.

4. ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн байгууллага, төрийн өмчийн компанийн олон нийтэд зориулсан мэдээллийн сүлжээнд ОҮИТБС-ын стандартын дагуу мэдээллийг байршуулах тухай Засгийн газраас гаргах тогтоолын хавсралтын төслийн тухай танилцуулга

Ш:Цолмон: 2017 оны ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар төрийн байгууллага, төрийн өмчийн компанийн олон нийтэд зориулсан мэдээллийн сүлжээнд ОҮИТБС-ын стандартын дагуу мэдээллийг байршуулах тухай Засгийн газрын тогтоолын хавсралтын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулахаар ярилцсан. Энэ танилцуулгыг ажлын хэсгийн хуралдаанаар ярьсан, нилээдгүй санал өгсөн. Энэ 6 дугаар сард болсон ОҮИТБС-ын олон улсын бага хурлаар төрийн захиргааны бүх шатны байгууллагууд байгаа цахим сүлжээгээ ашиглан олборлох салбарыг мэдээллийг ил тод болгох, тогтмолжуулах гэсэн санааг дэвшүүлсэн. ОУ-ын НБДНГ-аас судалгаа хийж Монгол улс "мэйнстрийминг" хийх бүрэн боломжтой гэж үзсэн. 2018 онд ажлын хэсэг байгуулагдсан боловч санхүүжилт саатсаны улмаас энэ удаад дахин танилцуулагдаж байна. 11 сард ажлын хэсгийн гишүүдээс санал авсан, ОҮИТБС-ын тайланд тусгах болон цахим хуудас дээрээ байршуулах мэдээллийн жагсаалт гээд яам тус бүрээр ямар ямар мэдээллийг ил тод байршуулах судалгааны дагуу оруулахаар бэлтгэсэн байна. Үүнийг хэлэлцэж шийдвэр гаргаж өгнө үү. /Танилцуулгыг хавсаргав/

Д.Дамба: Засгийн газрын тогтоолын төсөл нь байгаа юу? Бид Засгийн газрын хуралдаанд танилцуулаад шийдвэр гаргуулах хэрэгтэй байх. Танилцуулах горимоор явбал Засгийн газраас санал чиглэл авах боломжтой. Үндэсний зөвлөлийн дарга, сайд танилцуулаад үүний дагуу заавар журам боловсруулах эсвэл Засгийн газрын тогтоол гаргах талаар чиглэл өгнө байх. Хэрвээ тогтоол гаргуулна гэвэл бүх яамдаас санал авч байж гаргуулна, энэ маягаараа тогтоол гаргуулахад хэцүү батлагдах магадлал байхгүй.

Б.Батболд: Газрын хэвлийн нөхөн сэргээлт гэж орсон байна, энэ мэдээллийг хаанаас авах вэ? Бусад мэдээллүүд БОАЖЯ-наас гардаг.

Л.Төр-Од: Энэ нь хэвшүүлэн ил тод болгох гэсэн утгатай юм. Үүнийг тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй байх. Нээлттэй өгөгдлийн мэдээллийн бодлого гэсэн мэдээллийг нилээд дэлгэрэнгүй болгосон байгаа. Бид мэйнстрийм хийхдээ шинэ стандартай уялдуулж, олон улсын заавар журмыг ашиглан хийх, Нээлттэй өгөгдөл буюу нээлттэй засаглал, Ухаалаг засаг төсөлтэй хамтран ажиллах болон Засгийн газрын хөгжлийн урт хугацааны бодлогын төсөлд тусгуулвал холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахад дөхөм болох болов уу.

Д.Галбаатар:Түрүүн байгуулсан ажлын хэсэг энэ асуудлыг давхар хийгээд танилцуулаад, заавар журмыг батлуулаад ажиллах хэрэгтэй цаашилбал хуулийн ажлын хэсэгт бас ажиллах шаардлагатай гэж бодож байна. Эдгээрээс харахад томоохон шинэчлэлт хийгдэхээр байна.

Д.Дамба: За баярлалаа, гишүүдийн саналын дагуу энэ удаа Засгийн газрын тогтоол гаргуулахыг хойшлуулж байна, өмнөх ажлын хэсгийн удирдамжид давхар тусгаад ажиллана.

Н.Баярсайхан: Ирэх оны 2 дугаар сард ОУ-ын Удирдах хорооны хурал болох гэж байгаа. Монгол улс ОҮИТБС-ыг сайн хэрэгжүүлж байгаа орон учраас цаащдаа үйл ажиллагааг илүү өргөжүүлэхэд ямар бэрхшээл (санхүүжилт, арга зүй) тулгараад байгаа асуудлаар дэмжлэг хүссэн, албан тоот, хүсэлт явуулах саналтай байна. Бид ОҮИТБС-ын стратегитай байсан тэр маань дуусан дараагийн ирээдүйгээ харж чадахгүй байна тэгэхээр ойрын 2025 он хүртэл ч юмуу стратегийн баримт бичигтэй болъё. Үүнийг хэрэгжүүлэхэд арга зүй хэрэгтэй, үүнд чиглэл удирдамж хэрэгтэй байгаа учраас дээрх саналыг гаргаж байна. Бид ажлын тайлан гаргах аргачлалтай болъё гэсэн үүнийг бид өөрсдөө хийх боломжтой юу? эсвэл ОУ-ын Удирдах хороонд хандах боломжтой гэсэн санал байна.

Л.Төр-Од: Бидэнд "мэйнстрийминг" болон бенефициар өмчлөгчийн талаар туршлага судлах, арга зүйгээр хангах, техникийн туслалцаа дэмжлэг хэрэгтэй байгаа. Тухайлбал, мэйнстрийминг дээр хамгийн туршлагатай улс бол Норвег гэдэг. Миний хувьд Норвегийн ИНБ-тай холбогдож байхад тэдэнд хэрэгжилт дээрээ бас асуудал байгаа. Тэгэхээр бид энэ дээрээ илүү ахиц гаргах ёстой, өөрөөр хэлбэл хэрэгжилт болон арга зүйн талаасаа цогц ажлыг хэрэгжүүлмээр байна. Дараагийн санал бол Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор салбарын хууль, органик хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулна гэж ярьсан, үүнд ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт ордог хувийн хэвшил, Иргэний нийгмийн төлөөллийг оруулах саналтай байна. Үүнтэй холбогдуулан зарим хууль тогтоомжийн нэршил дээр ч оновчтой хандах хэрэгтэй байна. Тухайлбал, Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль гэх үү өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн нэр томъёо болон стандартын үг хэллэгт нийцүүлэх зарчмын саналтай байна, баярлалаа.

Д.Галбаатар: Бид ОУ-ын хороонд санхүүжилтийн асуудлаар хандсан, та нарыг санхүүжүүлж чадахгүй гэдгээ тэд хэлсэн харин бусад орнуудад тусла гэсэн. Тэгэхээр бид Дамба даргын хэлснээр яамны хажууд нэгжтэй болох тал дээр ажиллаж, үүнийг дэмжих саналтай байна.

Б.Батболд: Манай ИНБ-ийнхан ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд олон жил зүтгэж байгаа, төрийнхөн ч зүтгэж л байгаа. Оны эцэс болж байна, яам дотроосоо гурван төлөөллөөс нэг нэг хүнийг шагнах талаар шийдэх боломж байгаа байх.

Д.Дамба: ойлголоо, бидэнд цаг бага байна, үндсэндээ сайдын тушаал гарчиж байгаа. Нэмж оруулах асуудлыг удирдлагуудад танилцуулъя. Өнөөдөр нэрсийг нь товолчихъё гэхдээ амалж чадахгүй.

Л.Төр-Од: Байгалийн хий дамжуулах асуудал манай санаачилгатай холбоотой шүү. Украйн улс дамжуулдаг, ОҮИТБС-аараа дамжуулаад хянадаг байгаа. Үүнийг олборлох үйлдвэрлэл гэдэгт оруулах саналтай байна.

Н.Баярсайхан: Хэрвээ Батболдын энэ санал дэмжигдэж байгаа бол би нэрээ татаж байна. ТАН эвсэл хуралдаж байж хэнийг шагнуулахыг хэлэлцэж, нэр дэвшүүлэх байх, манай эвслийн дотоод зарчим ийм байгаа. Харин би Дундговь аймгийн Өлзийт сумын удирдлагууд өөрсдийн санаачилгаар ОҮИТБС-ын хэлэлцүүлгийг 6 дахь жилдээ тогтмол хийж байгаа. Байгууллагыг нь шагнуулах санал дэвшүүлж байна.

Д.Дамба: За өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаандаа идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа. Хуралдаан 16.20 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга,
ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн
ахлагч Г.Нандинжаргал

Тэмдэглэлийг хянасан:

УУХҮЯ-ны Хэлтсийн дарга Д.Дамба

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг